



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БОР-ӨНДӨР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 10 сарын 09 өдөр

Дугаар А/200

Бор-Өндөр сум


**Засаг даргын мөрийн хөтөлбөрийн зардлаас
хөрөнгө зарцуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.20 дахь хэсэг, Бор-Өндөр сумын Засаг даргын мөрийн хөтөлбөрийн 2.1.8 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Бор-Өндөр сумын Нэгдсэн эмнэлгийн дотрын эмч О.Оюунгэрэл нь 2023 оны 08 дугаар сараас эхлэн одоог хүртэл сумандаа тогтвор суурьшилтай ажиллаж байна. Суманд орон сууцны хүрэлцээ муу, түрээсийн үнэ өндөр байдаг тул О.Оюунгэрэл нь эмнэлгийн өрөөнд амьдардаг. Тус эмчийн орон сууцны асуудлыг шийдвэрлэхэд зориулж 1 жилийн түрээсийн төлбөр болох 4 200 000 (дөрвөн сая хоёр зуун мянга) төгрөгийг Засаг даргын мөрийн хөтөлбөрийн зардлаас зарцуулсугай.

2. Засаг даргын мөрийн хөтөлбөрийн зардлаас зохих хууль дүрэм, журмын дагуу зарцуулахыг санхүүгийн албаны дарга (Э.Түвшинсайхан)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Г.АДЪЯАБИЛЭГТ